



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 360

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 298 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Фронтээр ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 09 дугаар сарын 27-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Фронтээр ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрх бүхий ажилтны эрхийн үнэмлэхийн хугацааг СЗХ-ны “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ын 6.7, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2.1.1 дэх заалтыг үндэслэн сунгуулахыг /Игата Масатеру/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ